

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ



2026 оны 03 сарын 28 өдөр

Улаанбаатар хот

Тэнгэр Даатгал ХК (цаашид “Компани” гэх)-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 03 дугаар сарын 28-ны өдөр 15:00 цагаас 16:50 цагийн хооронд компанийн албан ёсны фейсбүүк <https://www.facebook.com/tengerinsurance> хаягаар дамжуулан цахим хэлбэрээр хуралдав. Санал хураалт болон асуултыг <https://www.investmentexpo.mn/> цахим хаягаар хураав.

Хурлын дарга: Шаравпэлжээ овогтой ГАНТУЯА

Хурлын нарийн бичгийн дарга: Алтангэрэл овогтой ДАВААДОРЖ

Тооллогын комисс: Э.Ариунзаяа /Комиссын дарга/
Д.Анударь, Т.Батмагнай /Гишүүд/

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигч нарын тоо: 16

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигч нарын саналын эрхтэй хувьцааны тоо:
50,565,543 ширхэг

Хурлын ирц: 84.28% буюу дийлэнх олонх.

НЭГ. МЭДЭЭЛЭЛ

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга А.Даваадорж “Тэнгэр Даатгал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдах шийдвэрийг 2026 оны 02 сарын 11-ний өдрийн ТУЗ-ийн ээлжит бус хурлаас шийдвэрлэсэн тухай мөн уг шийдвэрийн дагуу Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр 2026 оны 02 сарын 16-ны өдөр, 2026 оны 02 сарын 27-ны өдрүүдэд тус тус мэдээлснийг танилцуулав.

Хурлын зар болон хурлын материалыг Санхүүгийн зохицуулах хорооны 244 тоот тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-ын дагуу 2026 оны 02 сарын 20-ны өдрийн дотор брокер, дилерийн компаниудад цахим болон хэвлэмэл хэлбэрээр хүргүүлж, хувьцаа эзэмшигчдийн хурлын материалтай танилцах боломжоор хангаж ажилласан болохыг мэдэгдэв.

Мөн Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүртгэлийн өдрийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөс 2026 оны 03 сарын 03-ны өдрөөр тогтоосныг танилцуулав.

Тооллогын комиссын дарга Э.Ариунзаяа: Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц хураалтын аргачлал болон “Тэнгэр Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн хурлын шийдвэрээр томилогдсон Тооллогын комиссоос ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийн ирцийн бүртгэлийг танилцуулав.

2026 оны 03 сарын 28 өдөр

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах болсон шалтгаан, хуулийн үндэслэлийг танилцуулж, хурлаар хэлэлцэх асуудал, хурлын дэгийг танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга Ш.Гантуяа нээлтийн үг хэлснээр хурал албан ёсоор эхлэв.

ХОЁР. ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

1 дүгээр асуудал: Компанийн 2025 оны бизнесийн болон үйл ажиллагааны тайлан танилцуулах;

2 дугаар асуудал: Компанийн 2025 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;

3 дугаар асуудал: Компанийн ногдол ашиг тараах эсэх талаарх ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах;

4 дүгээр асуудал: Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;

5 дугаар асуудал: Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны төсвийг хэлэлцэн батлах;

Нэгдүгээр асуудал: Компанийн 2025 оны бизнесийн болон үйл ажиллагааны тайлан танилцуулах;

1. Хэлэлцсэн нь:

Танилцуулсан: “Тэнгэр Даатгал” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Баянмөнх

Танилцуулгын гол агуулга: Тэнгэр Даатгал ХК-ийн 2025 оны санхүүгийн үр дүн болон үйл ажиллагааны товч тайланг танилцуулав.

Хоёрдугаар асуудал: Компанийн 2025 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;

2025 оны тайлангийн жилд нийт хураамжийн орлого өмнөх оноос 6%-иар өсөж 29.7 тэрбум төгрөгт хүрсэн бол татварын дараах цэвэр ашиг 47.4%-ийн үсрэнгүй өсөлт үзүүлж, 10.6 тэрбум төгрөгт хүрлээ. Хөрөнгө оруулалтын багцын хэмжээ 60.8 тэрбум төгрөгт хүрснээр хөрөнгө оруулалтын орлого өмнөх оноос 31%-иар нэмэгдэж, 8.8 тэрбум төгрөгийн ашиг бүрдүүлсэн байна. Компанийн нийт хөрөнгө 75.6 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд үүнээс мөнгөн хөрөнгө 66.1 тэрбум төгрөгт хүрч, жилийн дотор 18.5 тэрбум төгрөгөөр

2026 оны 03 сарын 28 өдөр

Улаанбаатар хот

зузаарлаа. Ашигт ажиллагааны гол үзүүлэлтүүд болох эздийн өмчийн өгөөж (ROE) 24.9%, нийт хөрөнгийн өгөөж (ROA) 13.9%-тай гарсан нь компанийн санхүүгийн чадавх өндөр байгааг тус тус танилцуулав.

1. Хэлэлцсэн нь:

Танилцуулсан: "Тэнгэр Даатгал" ХК-ийн Аудит эрсдэлийн хорооны дарга Ж.Дэлгэрсайхан

Танилцуулгын гол агуулга: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайланд хязгаарлалтгүй хөндлөнгийн аудитын дүгнэлт (өөрөөр хэлбэл зөрчилгүй аудитын дүгнэлт) гаргасан болно. Бидний аудитын ажил 2026 оны 02 дугаар сарын 12-ны өдөр дууссан бөгөөд дараах горимуудыг гүйцэтгэсэн болно.

- Удирдлагад хүргүүлсэн эцсийн баталгаажуулах баримт бичгүүд болон асуултуудад өгсөн хариултууд;
- Тайлангийн дараах үйл явдлын хяналтыг хийх;
- Удирдлагын төлөөллийн захидал хүлээн авах;
- Удирдлагын гарын үсэгтэй хариуцлагын мэдэгдэл хүлээн авах.

Аудиторын дүгнэлт: Бид Тэнгэр Даатгал ХК (цаашид "Компани" гэх)-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Компанийн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон үеийн жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл ("НББОУСЗ")-өөс гаргасан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд ("СТОУС")-ын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл: Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт ("АОУС")-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагуудыг энэхүү тайлангийн "Санхүү тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага" хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан "Мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм"-ийн дагуу Компаниас хараат бус бөгөөд уг дүрэмд заасны дагуу өөрсдийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан

2026 оны 03 сарын 28 өдөр

Улаанбаатар хот

дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Гуравдугаар асуудал: Компанийн ногдол ашиг тараах эсэх талаарх ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах;

1. Хэлэлцсэн нь:

Танилцуулсан: “Тэнгэр Даатгал” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Баянмөнх

Танилцуулгын гол агуулга: “Тэнгэр Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн 2026 оны 02 сарын 05-ны өдрийн ээлжит хурлын 26/04 тоот шийдвэрээр ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн болохыг танилцуулав. “Тэнгэр Даатгал” ХК нь 2025 онд 10.56 тэрбум төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан бөгөөд 2025 оны татварын дараах цэвэр ашгаас нэгж хувьцаанд 114.4 төгрөг буюу нийт 6,864,000,000.00 (зургаан тэрбум найман зуун жаран дөрвөн сая) төгрөгийн ногдол ашиг хуваарилна.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдөр буюу 2026 оны 03 сарын 03-ны өдөр байхаар тогтоосон. Ногдол ашгийг 2026 оны 03 сарын 31-ний өдрийн дотор “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулан хуваарилах тухай мэдэгдэв.

Дөрөвдүгээр асуудал: Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;

1. Хэлэлцсэн нь:

Танилцуулсан: “Тэнгэр Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга А.Даваадорж

Танилцуулгын гол агуулга: 2025 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд гаргасан ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулъя. ТУЗ дараах дүгнэлтийг гаргасан байна. Үүнд:

Санхүүгийн үйл ажиллагаа: “Тэнгэр Даатгал” ХК-ийн 2024 оны 12 сарын 05-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ээлжит хурлын №24/020 тоот тогтоолоор “Тэнгэр Даатгал” ХК-ийн 2025 оны Бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны стратегийг баталсан. “Тэнгэр Даатгал” ХК нь 2025 оны Нийт

2026 оны 03 сарын 28 өдөр

Улаанбаатар хот

хураамжийн орлого 29.8 тэрбум төгрөг буюу өмнөх оноос 6%-иар өсөж, нийт даатгалын зах зээлийн 5.2%-ийг эзэлж байна.

Компанийн мөнгөн хөрөнгө 66.1 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын орлого 8.8 тэрбум төгрөгт хүрээд байна. “Тэнгэр Даатгал” ХК нь 2025 онд нийт 3,454 даатгуулагчид нөхөн төлбөрийн үйлчилгээ үзүүлснээр нийт 6.3 тэрбум тогрогийн нөхөн төлбөр олгож, нэхэмжилсэн нөхөн төлбөрийн 98%-ийг шийдвэрлэжээ. Нөхөн төлбөр шийдвэрлэлтийн дундаж хугацаа ажлын 2.7 хоног байна.

“Тэнгэр Даатгал” ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланг баталгаажуулах хөндлөнгийн аудитаар олон улсын “Нексия Глобал Монголиа Аудит” ХХК ажилсан бөгөөд “Тэнгэр Даатгал” ХК-ийн 2025 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон жилийн санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт-17 /СТОУС-17/-ын дагуу үнэн, зөв бодитойгоор илэрхийлсэн гэж дүгнэсэн байна.

Нийгмийн хариуцлага: Байгаль орчин нийгэм засаглалын хүрээнд дараах төслүүдийг хэрэгжүүлж нийгэмдээ бодит хувь нэмэр, үнэ цэнийг бүтээсэн гэж дүгнэж байна.

Үүнд:

- Монгол ахан дүүстээ даатгал эрсдэлийн боловсрол олгох зорилгоор сошиал платформд суурилсан Asuuna, Edoctor төслүүдийг хэрэгжүүлж давтагдсан тоогоор 7 сая гаруй иргэнд анхан шатны эрүүл мэндийн зөвлөгөө, эрсдэлийн боловсрол олгоод байна.
- Тэнгэр төгөл төслийг 2021 онд эхлүүлж байсан бол өдгөө 1,550 гаруй мод бут сөөгтэй, зуун хувийн ургалттай 3 га газар бүхий ногоон төгөл болжээ.
- Санхүүгийн салбарын тулгуур багана болох даатгалын салбарын чадварлаг мэргэжилтэн, актуарч бэлтгэх зорилгын дор Ажлын байр Тэтгэлэгтэй хөтөлбөрийг Санхүүгийн Эдийн Засгийн Их Сургуультай хамтран хоёр дах жилдээ амжилттай хэрэгжүүлж байна.

Тавдугаар асуудал: Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны төсвийг хэлэлцэн батлах;

1. Хэлэлцсэн нь:

Танилцуулсан: “Тэнгэр Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга А.Даваадорж

2026 оны 03 сарын 28 өдөр

Улаанбаатар хот

Танилцуулгын гол агуулга: Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны зардлын төсвийг дараах бүтэцтэйгээр хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэн батлуулахаар оруулж байна.

№	Зардлын төсөв	Нийт зардал (төгрөг)
1	ТУЗ-ийн дарга болон бусад найман гишүүн, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нарын цалин, урамшуулал	600,000,000
2	Хувьцаа эзэмшигчдийн хурал болон ТУЗ-ийн хурал	20,000,000
3	Бичиг хэрэг болон бусад	5,000,000
Нийт дүн		625,000,000

АСУУЛТ, ХАРИУЛТ

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга асуулт, хариулт эхэлснийг зарлаж тооллогын комиссын даргаас хувьцаа эзэмшигч нараас ирсэн асуултуудыг авав. Цахим хэлбэрээр хувьцаа эзэмшигчдийн хурал явагдаж байгаа тул бүх асуултад хариулах боломжгүй, асуултуудыг агуулгын хувьд ижил болон олон давхацсан асуултуудыг нэгтгэн хариулахаар сонгосныг тайлбарлав. Хувьцаа эзэмшигчид хурлын вэбсайт болох Investmentexpo.mn болон компанийн албан ёсны фейсбүүк хуудсаар дамжуулан ирүүлсэн асуултыг нэгтгэснийг мөн нэмж тайлбарлав.

Асуулт 1: 2025 оны цэвэр ашгаас 65%-ийг ногдол ашиг хэлбэрээр хуваарилна гэсэн байсан. Ирэх жил мөн ногдол ашиг хуваарилах уу? Цэвэр ашгийн хэдэн хувийг хуваарилах бол?

Хариулт “Тэнгэр Даатгал” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Баянмөнх:

Бид Монголын хөрөнгийн бирж дээр 2024 оны эцэст IPO хийсэн. Тухайн үед олон нийтэд хувьцаагаа санал болгох үед ногдол ашиг суурьтай хувьцааны хөрөнгө оруулалтын стратеги баримталж байв. Бодлогын баримт бичиг дээр 3 жил дараалан цэвэр ашгаасаа ногдол ашиг хуваарилах талаар мөн тусгасан. 2025 оны тухайд цэвэр ашгийн 65%-ийг хуваарилж байна. 2026 оны тухайд зах зээлийн нөхцөл байдал, компанийн ашигт ажиллагаанаас хамаарна гэж харж байна.

2026 оны 03 сарын 28 өдөр

Улаанбаатар хот

Асуулт 2: Харилцагч, даатгуулагчийн мэдээллийг хамгаалах ямар бодлого баримталдаг вэ? Сүүлийн үед хувийн мэдээлэл алдагдах тохиолдол цөөнгүй байх юм.

Хариулт “Тэнгэр Даатгал” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Баянмөнх:

Бид олон нийтэд нээлттэй хувьцаат компани болсноор бизнесээ илүү тэлье, харилцагчдадаа даатгалын үйлчилгээг илүү хурдан, хялбар үзүүлэхийг зорьж байсан. Үүний хүрээнд бид системүүдээ хөгжүүлсэн, тэр хэрээрээ харилцагчийн нууцлалыг өндөр байлгах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах шаардлага нэмэгдсэн. Бид 2025 оноос хойш олон улсын мэдээллийн аюулгүй байдлын ISO 27001 стандартыг нэвтрүүлэхээр зорилго болгон ажиллаж байна. Үүний хүрээнд нийт даатгуулагчдын хувийн мэдээлэл, компанийн санхүүгийн, хөрөнгийн мэдээлэл зэргийг чандлан хадгалах ажлууд хийгдсээр байна.

Асуулт 3: Компанийн ашиг, орлогын өсөлтийг нэмэгдүүлэхийн тулд ямар стратеги баримтлан ажиллаж байна вэ? Ирээдүйд хэрэгжүүлэх гол стратегиуд юу вэ?

Хариулт “Тэнгэр Даатгал” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Баянмөнх:

Монголын даатгалын зах зээл төдийлөн сайн хөгжөөгүй, оролцогчид нэмэгдэж байгаа ч зах зээлийн өсөлт удаан байна. Энэ нь дэлхийн болон дотоодын эдийн засгийн тогтворгүй байдлаас шалтгаалах зүйл. 2026 онд ч энэ нөхцөл байдал үргэлжлэх хандлагатай. Иймд компани хурдан тэлэхээс илүү харилцан ашигтай, тогтвортой түншлэлүүдийг бэхжүүлэх стратеги баримтална. Нэг ёсондоо даатгалын нөхөн төлбөр олгохоос гадна эрсдэлийг бууруулах, даатгалын боловсрол олгох, төрийн байгууллагуудтай хамтран ажиллах чиглэлд анхаарч байна. Хэт өсөлтийг зорихоос илүү урт хугацааны тогтвортой түншлэлийг зорьж ажиллана. Мөн системийн сайжруулалт, хиймэл оюун ухаан, программ хангамж зэргийг сайжруулах болно.

Асуулт 4: Байгаль орчин нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдэж буй ажлууд компанийн бизнесийн стратегитай хэрхэн уялдаж байгаа вэ?

Хариулт “Тэнгэр Даатгал” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Баянмөнх:

Олон нийтийн боловсрол, эрүүл мэндийн асуудал бол ялт үгүй Монгол улсын эхэнд тавих асуудал. Компаниуд жижиг, том гэлтгүй оролцоогоо нэмэх хэрэгтэй. Тиймээс манай компани оюутан, залуус руу чиглэсэн ажлаас авхуулаад олон нийтийн даатгалын боловсролыг нэмэгдүүлэх, эрсдэлийн

2026 оны 03 сарын 28 өдөр

Улаанбаатар хот

тухай буруу ойлголт залруулах ажлыг төлөвлөж ажиллаж байна. Эдгээр ажлууд нь нийгэмд зөв мэдээлэл түгээх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх мэдлэг олгох зорилготой бөгөөд 2026 оны эцэс гэхэд бодит үр дүн гаргана гэж үзэж байна.

Асуулт 5: Энэ жил тэнгэр даатгал компанийн 25 жилийн ой гэж байсан. Энэ хүрээнд онцлох ямар ажлууд төлөвлөгдсөн бэ?

Хариулт “Тэнгэр Даатгал” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Баянмөнх:

Энэ жил манай компанийн 25 жилийн ой тохиож байна. Амжилтын үндэс нь урт хугацааны, итгэлцэлд суурилсан түншлэл байдаг. Ойн хүрээнд харилцагчдын мэдээллийн аюулгүй байдлыг хангах ISO стандартыг нэвтрүүлэхээр ажиллаж байна. Мөн Мандал санхүүгийн нэгдлийн жил бүр зохион байгуулдаг эрсдэлийн форумд хамтран оролцож, гадаадын зочид, төлөөлөгчдийг урина. Үүнээс гадна харилцагчдад чиглэсэн урамшуулалт хөтөлбөрүүд хэрэгжүүлэх бөгөөд гол зорилго нь эрсдэлийг гарсны дараа бус, урьдчилан сэргийлэхэд чиглэнэ.

САНАЛ ХУРААЛТ

Танилцуулсан: Тооллогын комиссын дарга Э.Ариунзаяа

Танилцуулгын гол агуулга: Санал хураалтын систем ашиглан хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгөх зааврыг танилцуулав.

КОМПАНИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТУЗ-ИЙН ГАРГАСАН ДҮГНЭЛТИЙГ БАТЛАХАД АСУУДЛААР САНАЛ ХУРААСАН ДҮН:

“Тэнгэр Даатгал” ХК-ийн 2025 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлахад өгсөн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 50,564,893 ширхэг хувьцааны санал буюу 100 хувийн саналаар 2025 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлав.

КОМПАНИЙН ТУЗ-ИЙН 2026 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ АСУУДЛААР САНАЛ ХУРААСАН ДҮН:

ТУЗ-ийн 2026 үйл ажиллагааны зардлын төсөв батлахад өгсөн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 50,564,893 ширхэг хувьцааны санал буюу 100 хувийн саналаар ТУЗ-ийн 2026 оны үйл ажиллагааны зардлын төсөв батлав.

Тооллогын комиссын дарга Э.Ариунзаяа: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарч буй тооллогын комиссын тогтоолын төслийг уншиж танилцуулав.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ



2026 оны 03 сарын 28 өдөр

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга "Тэнгэр Даатгал" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарч буй хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолын төслийг уншиж танилцуулав.

Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Баянмөнх нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал амжилттай болсныг мэдэгдэж, хуралд идэвхтэй оролцсон нийт хувьцаа эзэмшигчдэдээ талархал илэрхийлэхийн зэрэгцээ Тэнгэр Даатгал компанийн 25 жилийн ойн баярын мэндийг дэвшүүлснээр ээлжит хурал 16 цаг 50 минутад өндөрлөв.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

Гарын үсэг: 

Нэр: А.Даваадорж

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

ТАНИЛЦСАН:

Гарын үсэг: 

Нэр: Ш.Гантуяа

Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга

